

2020

МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН



ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ
ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГТ
ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХ ТАСЛАН
СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ
АВЧ БУЙ БАЙДАЛ



Хүчирхийллийн эсрэг
үндэсний төв



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарин хөгжлийн агентлаг





Хүчирхийллийн эсрэг
үндэсний төв



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг



ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГТ ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ БУЙ БАЙДАЛ

МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2020 он

ОРШИЛ

НЭГ. МОНИТОРИНГИЙН ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

- 1.1. Үндэслэл
- 1.2. Мониторингийн зорилго
- 1.3. Хамрах хүрээ
- 1.4. Арга зүй

ХОЁР. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГТ ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ БУЙ БАЙДАЛ

- 2.1. Эрх зүйн орчин
- 2.2. ГБХ үйлдэх гэмт хэрэгт хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авч буй байдал
- 2.3. Хязгаарлалт тогтоох таслах сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж буй байдал
- 2.4. Төсөв, санхүүжилт

ГУРАВ. ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

- 3.1. Дүгнэлт
- 3.2. Зөвлөмж

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖУУД
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ
ЦЕГ - Цагдаагийн ерөнхий газар
ХЭҮТ - Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ТСАХ - Таслан сэргийлэх арга хэмжээ
ЭХХШт - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ГБХ - Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХТт - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ХЭҮК - Хүний эрхийн үндэсний комисс
ШШГ - Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

МОНИТОРИНГИЙН БАГ

Хэрэгжүүлэгч байгууллага:

“Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” ТББ

Мэдээллийг нэгтгэж тайлан бичсэн:

Х.Мөнхзул, ХЭҮК-ын ахлах референт
Н.Арвинтэриа, ХЭҮТ-ийн захирал
С.Байгалмаа, ХЭҮТ-ийн хөтөлбөрийн менежер

Мэдээлэл цуглуулагчид:

С.Батжаргал, МХХ-ын гишүүн, өмгөөлөгч
Ч.Одончимэг, ХЭҮТ-ийн хуулийн зөвлөгч
Д.Санчир, ХЭҮТ-ийн хуулийн зөвлөгч
Б.Сүндэрмаа, ХЭҮТ-ийн Дархан-Уул аймаг дахь салбарын зохицуулагч
Д.Үржинханд, ХЭҮТ-ийн хуулийн зөвлөгч
Б.Должинсүрэн, ХЭҮТ-ийн ажилтан

Орчуулсан:

Х.Нуржан, Хүмүүнлэгийн Их сургуулийн англи хэлний багш

Хянан тохиолдуулсан:

Ц.Алтанцэцэг, Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш,
дэд професор

Хаяг:

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ, Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу, 40-р байр 03, 06 тоот
И-мэйл: mongolcav@gmail.com
Вэб сайт: www.safefuture.mn

НЭГ. МОНИТОРИНГИЙН ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

1.1. Мониторингийн үндэслэл

Монгол Улс 2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай (ГБХТ) хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд уг хууль нь эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээний бусад хуулиудтай нягт уялдаатай батлагдсан. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (ЭХХШТ) хуульд хохирогчийг хамгаалах зохицуулалт нарийвчлан тусгагдсан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шударгаар шүүлгэх эрхийг хангах асуудлыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн тусгасан. Тухайлбал, ЭХХШТ хуулийн 14.5 дугаар зүйлд яллагдагчийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарахыг хязгаарлах, тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох, тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгаж, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг прокурорын саналыг үндэслэн шүүх авахаар заасан нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг дахин гэмт халдлагад өртөхөөс хамгаалахад ихээхэн ач холбогдолтой шинэлэг зохицуулалт юм.

ГБХТ тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхлээд 3 жил гаруй хугацаа өнгөрч байгаа хэдий ч хохирогчийн аюулгүй байдлыг хангахад нэн шаардлагатай “Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авах” тухай зохицуулалт нь гэр бүлийн хүчирхийллийн холбогдолтой хэргүүдийг хянан шийдвэрлэх практикт тэр бүр хэрэглэгдэхгүй байна.

Хохирогч хуулийн энэхүү хамгаалалтыг авч чадалгүй давтан хохирох явдал гарч байгаад анхаарал хандуулж, ЭХХШ тухай хуулийн 14.5 дугаар зүйлийн хэрэгжилт бодит байдал дээр ямар байгааг үнэлэх, хэрэгжилтийн явц дахь хүндрэл, бэрхшээлийг илрүүлэн цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү мониторингийг хийв.

Мониторингийн баг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” болон ХЭҮТ-ийн төслийн багаас баталсан мониторинг хийх удирдамжийг баримталсан болно.

1.2. Мониторингийн зорилго


Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.5 дугаар зүйлд заасан хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийн бодит нөхцөл байдал, үр дүнг үнэлэх, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, боловсронгуй болгох нөхцөл боломж, аргачлалыг эрэлхийлэх.

1.3. Мониторингийн хамарсан хүрээ

Мониторингт Дархан-Уул, Дундговь, Хэнтий, Төв, Баянхонгор, Өвөрхангай аймгууд болон Нийслэлийн Баянзүрх, Багахангай, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийг тус тус хамруулан мэдээлэл цуглууллаа.

Мониторингийн хүрээнд сонгогдсон орон нутгийн Шүүхийн тамгын газар, хэлтэс, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн таслан сэргийлэх арга хэмжээ хариуцан ажиллаж буй шүүгч нар, Прокурорын газрын хяналтын прокурор, мөн Цагдаагийн газар, гэр бүл хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх хэлтэс болон мөрдөн байцаагч нар, гэр бүлийн хүчирхийллийн холбогдолтой гэмт хэргийн хохирогч, МӨХ-ны гишүүн өмгөөлөгч зэрэг нийт 90 хүнтэй ганцаарчилсан болон фокус бүлгийн уулзалт хийлээ.

Зураг 1. Ганцаарчилсан ярилцлага болон фокус бүлгийн уулзалтад оролцогчид



- Мөн хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрүүдийг цуглуулж, үнэлгээ хийлээ.
- Мэдээлэл цуглуулах явцад хязгаарлалт тогтоох арга хэмжээ авахуулах хүсэлтийг хохирогчийн өмгөөлөгчөөр гаргуулан, шүүх хүсэлтийг хэрхэн шийдвэрлэж байгаа байдалд ажиглалт хийв.
- ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс гэмт хэргийн гэрч, хохирогчид аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлж байгаа талаарх мэдээлэлтэй танилцсан.
- Түүнчлэн Улсын Ерөнхий Прокурорын газар, Шүүхийн судалгаа, мэдээлэл сургалтын төв, Цагдаагийн Ерөнхий газраас холбогдох мэдээллийг цуглууллаа.

Хүснэгт 1. Судалгааны хамарсан хүрээ, түүвэрлэлт

№	Үйл ажиллагаа	Ашиглах материал	Түүвэрлэлт
1.	Мэдээлэл, тоо баримт цуглуулах	Хавсралт 1 Асуумжийн хуудас	ГБХ-ийн нөхцөл байдал, түүн дотор гэмт хэргийн гаралтын түвшний талаарх тоо баримтыг цагдаа, прокурор, шүүхийн статистикаас түүвэрлэх
2.	Хязгаарлалт тогтоох ТСАХ авсан шүүгчийн захирамжид дүн шинжилгээ хийх	Хавсралт 2	-Шүүгчийн захирамж
3.	Холбогдох субъектүүдээс судалгаа авах	Хавсралт 3	-Шүүхийн судалгаа, мэдээллийн төв -УЕПГ -ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс
4.	Цагдаа, прокурор, өмгөөлөгч, хохирогчтой ярилцлага хийх	Хавсралт 4 Бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага	-6 аймаг, 3 дүүргийн шүүгч, прокурор, мөрдөгч, нийт 27 хүн
5.	Холбогдох бичиг баримтуудыг судлах	Хавсралт 5	-Хязгаарлалт тогтоох ТСАХ хэрэгжүүлэхтэй холбоотой журам, удирдамж, төлөвлөгөө -ТСАХ-ний хэрэгжилтэд хийсэн судалгаа

1.4. Мониторинг хийсэн арга зүй

1. Мэдээлэл, тоо баримт цуглуулах;
2. Холбогдох субъектүүдээс судалгаа авах (Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж буй зохион байгуулалт, нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, үр дүн);
3. Холбогдох талуудтай ярилцлага хийх (хохирогч, өмгөөлөгч, цагдаа, прокурор, шүүгч);
4. Холбогдох баримт бичгүүдийг судлах.

Мэдээлэл, тоо баримт цуглуулах: Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны тайлан, илтгэлүүдийг уншиж судлах, статистик тоо баримт цуглуулах ажлыг гүйцэтгэлээ.

Холбогдох талуудаас судалгаа авах хүрээнд: Шүүхийн судалгаа, мэдээллийн төв, УЕПГ, ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс боловсруулсан тусгай асуулгын дагуу судалгаа авлаа.

Талуудтай хийх ярилцлагын хүрээнд: Хязгаарлалт тогтоох ТСАХ-г хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг илрүүлэхийн тулд урьдчилан бэлтгэсэн асуулгын хуудсыг ашиглан мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч, хохирогч зэрэг нийт 90 хүнтэй уулзаж ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийсэн.

Баримт бичгийн судалгаа: Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой олон улсын эрх зүйн баримт бичиг болон ЭХХШ тухай хуульд заасан хязгаарлалт тогтоох ТСАХ, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам, удирдамж, төлөвлөгөө, ТСАХ-ний хэрэгжилтэд хийсэн судалгааны материалуудыг судалсан болно.

ХОЁР. ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ БУЙ БАЙДАЛ

2.1. Эрх зүйн орчин

“Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай” тунхаглалын 6 дугаар зүйлд гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангахыг улс орнуудад уриалсан¹.

“Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг” конвенцийн 13 дугаар зүйлд хохирогч болон гэрчүүдийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ авахыг конвенцид нэгдсэн улс орнуудад үүрэг болгосон².

Монгол Улсын Үндсэн хуульд³ хүн бүр “амьд явах, халдашгүй байх, эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах”, “төрөөс хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”,⁴ “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэний ч эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газар 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “хүчирхийлэлд өртөгчийг хамгаалах, хууль заавал хэрэгждэг, хүний эрхийн мэдрэмжтэй, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтлан” ажиллана хэмээн тунхаглажээ.

ЭХХШ тухай хуулийн Арван дөрөвдүгээр бүлэгт таслан сэргийлэх арга хэмжээний зохицуулалт тусгагдсан. Уг хуулийн 14.1 дүгээр зүйлд яллагдагч, шүүгдэгчид авах таслан сэргийлэх арга хэмжээний нэг төрөл нь “хязгаарлалт тогтоох”⁵ таслан сэргийлэх арга хэмжээ байхаар хуульчилсан.

1 НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор батлагдсан.

2 НҮБ-ийн 1984 оны конвенц

3 Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл

4 Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

5 ЭХХШ тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт

Цагдаагийн байгууллага: Улсын хэмжээнд 2017 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 1286 гэмт хэрэг, 2018 онд 1062 гэмт хэрэг, 2019 онд 985 гэмт хэрэг бүртгэгдсэн байна⁶. 2019 онд бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн 93.6 хувь нь хөнгөн, 6.4 хувь нь хүнд хэлбэрээр үйлдэгдсэн байна. ГБХ-ийн гэмт хэргийн 50.2 хувь нь Улаанбаатарт, 49.8 хувь нь орон нутагт бүртгэгдсэн⁷.

2019 онд гэр бүлийн хүчирхийлэлд 894 иргэн өртөж, хохирсны 89 хувь нь эмэгтэйчүүд, 7.7 хувь нь хүүхэд байна. Хүчирхийлэл үйлдэгчдийн 90 гаруй хувийг эрчүүд эзэлдэг. Энэ төрлийн гэмт хэргийн 80 гаруй хувь нь бие махбодийн хүчирхийлэлтэй холбоотой байсан⁸ ба уг гэмт хэргийн улмаас найман хүн амиа алдаж, 732 хүн гэмтэж бэртсэн⁹.

Зөвхөн 2020 оны эхний 8 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 1.4%-иар, зөрчил 36.8%-иар тус тус өссөн. Хохирогчдын 89.4 хувийг охид, эмэгтэйчүүд, 7.8 хувийг хүүхэд эзэлж байна¹⁰.

Шүүх: 2018 онд улсын хэмжээнд шүүхээр шийдвэрлэгдсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг өмнөх оноос 56 хэргээр буюу 94.9 хувиар, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 2.2 дахин өссөн байна¹¹. 2019 онд шүүхээр таслагдсан гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо 82.6 хувиар нэмэгдсэн байна¹².

2.3. Шүүхээс хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авч буй байдал

ЭХХШТХ-ийн 14.5 дугаар зүйлд заасан хязгаарлалт тогтоох ТСАХ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, яллагдагч, шүүгдэгчийг нэмж гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нөгөө талаас хохирогчийг хамгаалах агуулга, зорилготой байна.

Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ нь хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай

6 Цагдаагийн байгууллагын статистик мэдээлэл. <https://www.police.gov.mn>

7 ЦЕГ, ГБХ-ийн гэмт хэргийг анхан шатанд нь илрүүлж, шийдвэрлэж байна ярилцлага, цагдаагийн дэд хурандаа Б.Цэнгэлбаяр, 2020-3-10

8, 9 ЦЕГ, ГБХ-ийн гэмт хэргийг анхан шатанд нь илрүүлж, шийдвэрлэж байна ярилцлага, цагдаагийн дэд хурандаа Б.Цэнгэлбаяр, 2020-3-10

10 ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийн мэдээ, 2020 он

11 Монгол Улсын шүүхийн 2018 оны бүтэн жилийн шүүн таслан ажиллагааны тайлан, ШЕЗ, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн judinstisute.mn

12 Монгол Улсын Шүүхийн 2019 оны бүтэн жилийн шүүн таслан ажиллагааны тайлан, ШЕЗ

баримтыг үндэслэн прокурор эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсаны дараа ЭХХША-ны явцад яллагдагчийн Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөний зарим хэсгийг тодорхой хугацаагаар хязгаарлах албадлагын шинжтэй арга хэмжээ юм. Уг ТСАХ нь:

- тогтоосон газраас гарч явахыг хязгаарлах,
- тогтоосон нутаг дэвсгэрээс гарч явахыг хязгаарлах;
- Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах;
- тодорхой газар очихыг хориглох;
- тодорхой хүнтэй уулзахыг хориглох;
- тогтоосон замаар зорчихыг даалгах гэсэн төрлүүдтэй ба яллагдагчид хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэхийг прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэх¹³ зохицуулалттай байна.

Монгол Улсын хэмжээнд 2017-2019 онд ЭХХШ тухай хуулийн 14.5 дугаар зүйлд зааснаар нийт 999 хүнд холбогдох хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авахуулах саналыг шүүх шийдвэрлэжээ¹⁴.

Хүснэгт 2. Шүүхээс хязгаарлалт тогтоох ТСАХ авахуулах саналыг шийдвэрлэсэн байдал

№	Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний төрөл	2017	2018	2019
1	Тогтоосон газраас гарч явахыг хязгаарлах	5	3	6
2	Тогтоосон нутаг дэвсгэрээс гарч явахыг хязгаарлах	5	7	3
3	Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах	187	377	341
4	Тодорхой газар очихыг хязгаарлах	0	3	5
5	Тодорхой хүнтэй уулзахыг хориглох	2	20	35
6	Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх	0	0	0
7	Бүгд	199	410	390
8	Хязгаарлалт тогтоох ТСАХ-г өөрчлөх тухай	9	3	11
9	Хязгаарлалт тогтоох ТСАХ-г хүчингүй болгох тухай	20	42	53

13 ЭХХШ тухай хуулийн 14.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

14 Монгол Улсын шүүхийн 2017, 2018, 2019 оны бүтэн жилийн шүүн таслан ажиллагааны тайлан, ШЕЗ, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн judinstisute.mn

Шүүхээс хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авсан хүний тоо 2017 онд 199 байсан бол 2019 оноос 390 болж, 191 хүнээр буюу 50 шахам хувиар өсчээ. Энэ хугацаанд шүүхээс хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилсөн 23, хүчингүй болгосон 115 шийдвэрийг гаргасан байна.

Шүүн таслах ажиллагааны тайлангаас үзвэл хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний төрлүүдээс “Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах” ТСАХ-г сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид авсан тохиолдол хамгийн их байсан бол “тогтоосон замаар зорчихыг даалгах” ТСАХ-г практикт огт хэрэглээгүй байна.

2.4. Сонгогдсон орон нутагт гэр бүлийн хүчирхийллийн холбоотой хэргүүдийн яллагдагчид хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авч буй байдал

Сонгогдсон орон нутгийн цагдаагийн байгууллагад 2017 оны 7 дугаар сарын 1-нээс 2020 оны эхний улирлын хооронд ЭХ-ийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх)-д зааснаар нийт 357 хэрэг бүртгэгджээ.

Хүснэгт 3. Сонгогдсон орон нутагт бүртгэгдсэн ГБХ-ийн гэмт хэрэг


Аймаг, дүүргийн нэр	2017.07.01-2017.12.31	2018	2019	2020 оны эхний улирал	Орон нутгийн дүн
Дундговь аймаг	5	5	3	6	9
Өвөрхангай аймаг	9	5	7	3	35
Баянхонгор аймаг	0	187	377	341	5
Хэнтий аймаг	0	0	3	5	20
Багахангай дүүрэг	1	2	20	35	6
Дархан уул аймаг	4	0	0	0	17
Төв аймаг	2	199	410	390	19
Баянзүрх дүүрэг	14	9	3	11	124
Сонгинохайрхан дүүрэг	38	20	42	53	91
Баянгол дүүрэг	17	10	2	2	31
Нийт дүн	90	108	135	24	357

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргүүдэд хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэн хэрэглэж байгааг дээрх орон нутагт Эрүүгийн хуулийн доорхи зүйл ангиудад заасан гэмт хэргийн хүрээнд судаллаа:

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүнийг санаатай алах -10.1 дүгээр зүйлийн 2.8 дахь заалт;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах-11.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах 11.4 дүгээр зүйл 2.1 дэх заалт;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах-11.6 дугаар зүйл 2 дахь хэсэг;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх -11.7 дугаар зүйл;
- Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэх 12.1 дүгээр зүйлийн 2.3 дахь заалт.

2018 оноос 2020 оны эхний хагас жилийн байдлаар гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй эрүүгийн хэргийн яллагдагч нийт 33 хүнд ЭХХШТХ-ийн 14.5-д заасан “Хязгаарлалт тогтоох” таслан сэргийлэх арга хэмжээг авчээ¹⁵.

Зураг 2. Хязгаарлалт тогтоох ТСАХ авсан байдал



¹⁵ Сонгогдсон аймаг, дүүргүүдийн шүүхээс авсан судалгаа, ХЭҮТ, 2020 он

Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах

2018-2020 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын хилээр гарч явахыг хязгаарлах таслан сэргийлэх арга хэмжээг нийт 14 яллагдагч, шүүгдэгчид авчээ. Энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авсан тохиолдлыг хэргийн зүйлчлэлээр нь авч үзвэл:

- 11.4 дүгээр зүйлийн 2.1. (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах) -1;
- 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах) -3;
- 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх) -2;
- 12.1 дүгээр зүйлийн 2.3 дахь заалт (Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэх) -8 байна.

Тодорхой газар очихыг хорилох, тодорхой хүнтэй уулзахыг хориглох

Уг таслан сэргийлэх арга хэмжээг 2018 оноос хойш нийт 19 хүнд авсан байх бөгөөд хэргийн зүйлчлэлээр задлан харуулбал:

- 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах) -4,
- 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх) - 14,
- 12.1 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэг (Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэх) -1 тус тус байна.

Тогтоосон газраас гарч явахыг хязгаарлах, тогтоосон нутаг дэвсгэрээс гарч явахыг хязгаарлах

Энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг 2018 оноос хойш 2020 оны I улирлыг дуусталх хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн холбогдолтой хэргүүдэд хэрэглэсэн нэг ч тохиолдол бүртгэгдээгүй байна.

Тогтоосон замаар зорчихыг даалгах

Энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг 2018 оноос хойш 2020 оны I улирлыг дуусталх хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн холбогдолтой хэргүүдэд хэрэглэсэн нэг ч тохиолдол бүртгэгдээгүй байна.

Шүүхүүд хязгаарлалт тогтоох ТСАХ-ний төрлүүдээс тодорхой газар очихыг хориглох, тодорхой хүнтэй уулзахыг хориглох ТСАХ-г гэр бүлийн

хүчирхийлэл үйлдэх¹⁶ гэмт хэргийн яллагдагчид хамгийн олон (14) хэрэглэсэн бол Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах арга хэмжээг гэр бүлийн хамаарал бүхий хүнийг хүчиндэх¹⁷ гэмт хэрэг үйлдсэн яллагдагчид хамгийн олон (8) хэрэглэсэн байна.

Тогтоосон газраас гарч явахыг хязгаарлах, тогтоосон нутаг дэвсгэрээс гарч явахыг хязгаарлах, тогтоосон замаар зорчихыг даалгах ТСАХ-г яллагдагч, шүүгдэгчид аваагүй шалтгааныг тодруулахад уг ТСАХ-ний хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн үндэс бүрдээгүй, хяналтыг хэн, хэрхэн хэрэгжүүлэх процесс нь тодорхойгүй, иргэдийн эрх зүйн мэдлэг, ойлголт хангалтгүй байгаатай холбон тайлбарлаж байв.

2.5. Мөрдөгчөөс яллагдагчид хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авахуулах хүсэлт гаргаж байгаа байдал

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч нарт хамгийн их тулгамддаг асуудал нь хүчирхийлэл үйлдэгчийн эсрэг хуулийн байгууллагад хандсанаас хойш учирдаг дарамт, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд нь учирч болзошгүй эрсдэл байдаг. Тийм учраас ГБХТ тухай хууль болон ЭХХШ тухай хуульд хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой зохицуулалтууд тусгагдсаны нэг нь “хязгаарлалт тогтоох” таслан сэргийлэх арга хэмжээ юм.

Мөрдөгч мөрдөн байцаалтын явцад яллагдагчид зөвхөн “хувийн баталгаа гаргах” таслан сэргийлэх арга хэмжээг бие даан авах эрхтэй¹⁸. Харин хязгаарлалт тогтоох ТСАХ авах шаардлагатай бол прокурорт хүсэлтээ тавьж, прокурор шүүхэд санал гарган шийдвэрлүүлэхээр зохицуулсан¹⁹ байна.

Хэрэг бүртгэгч, мөрдөгчдөөс прокурорт яллагдагчид хязгаарлалт тогтоох ТСАХ авахуулах хүсэлт тавьсан 10 тохиолдол байна. Үүнээс яллагдагчид Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах 5, тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох таслан сэргийлэх арга хэмжээ авахуулах 5 хүсэлтийг прокурорт гаргажээ. Шүүх Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах 5 хүсэлтийг хангаж шийдсэн ба тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох таслан сэргийлэх арга хэмжээ

16 ЭХТА-ийн 11.7 дугаар зүйл

17 ЭХТА-ийн 12.1 дүгээр зүйлийн 2.3

18 ЭХХШ тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

19 ЭХХШ тухай хууль

авахуулах 5 хүсэлтээс 3-ыг нь хангаж, 2-ыг нь цагдан хорих ТСАХ болгон өөрчилсөн байна.

Хилээр гарахыг хориглох арга хэмжээг авч байгаа нь хэрэгжихэд тодорхой байдаг. Хил хамгаалах газар болон гадаадын иргэн харьяатын албанд хүсэлт өгөөд биелүүлэх боломжтой.

Гэхдээ прокуророос саналтай орж ирвэл авч болохгүй зүйл гэж байхгүй. Хөдөө орон нутагт тодорхой газар очихыг хориглох, тодорхой хүнтэй уулзахыг хориглох арга хэмжээг яг одоогоор биелүүлэх боломжгүй байгаа. Хохирогч ч юм уу, энэ таслан сэргийлэх арга хэмжээг зөрчөөд байна гэж хэлвэл өөр арга хэмжээгээр солих боломжтой.

Шүүгчтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс

Мөрдөгч шууд хязгаарлалт тогтоох ТСАХ авах эрхгүй. Хэргийн оролцогчоос хүсэлт гаргасны үндсэн дээр мөрдөгч хүсэлтээ прокурорт гаргадаг процесс байгаа. Тэгээд ч энэ хязгаарлалт тогтоох ТСАХ-нээс Монгол Улсын хилээр гарахыг хориглохоос бусад нь орон нутагт хэрэгжих боломжгүй. Техникийн хяналтын төхөөрөмж нь байхгүй, байсан ч хэн яаж хяналт тавих талаар тусгай журам байхгүй болохоор хэрэгжүүлэхэд хүндрэлтэй. Тэгээд ч шат дамжлага ихтэй учир бид ихэнхдээ яллагдагчаар гэрч, хохирогчид нөлөөлөхгүй, дахин гэмт хэрэг үйлдэхгүй гэсэн хувийн баталгаа гаргуулж, гарын үсэг зуруулж авдаг. Гэрч, хохирогчийг хамгаалах шийдвэр гаргуулсан цөөхөн л тохиолдол бий. Явж явж бид өөрсдөө л хяналт тавьдаг. Хаа явж байгааг нь утасдаж асууна, дуудаж ирүүлнэ, хохирогчоос асууж тодруулна. ТСАХ-г зөрчсөн тохиолдолд цагдан хорих ТСАХ-ээр солиулдаг.

*Хэрэг бүртгэгч, мөрдөгч нартай хийсэн фокус
бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс*

2.6. Прокуророос яллагдагчид хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авахуулах санал гаргаж буй байдал

ЭХХШ тухай хуульд яллагдагчид хязгаарлалт тогтоох ТСАХ авахуулахад прокурор голлох үүрэгтэй байхаар хуульчилжээ. Тухайлбал, прокурор нь ЭХХША-ны аль ч үед хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг яллагдагчид авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацааг сунгах саналыг өөрийн санаачилгаар, эсхүл мөрдөгчийн саналыг хүлээн авснаас хойш 24

цагийн дотор²⁰ шүүхэд гаргах,²¹ уг таслан сэргийлэх арга хэмжээг авсан, хүчингүй болгосон тухай шүүхийн шийдвэрийг прокурор, мөрдөгч хяналт тавих байгууллагад даруй мэдэгдэх үүрэгтэй²² гэж заасан.

Энэхүү мониторингийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдох гэмт хэргүүдэд прокуророос яллагдагчид хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авахуулах саналыг шүүхэд гаргасан байдлын талаарх статистик тоон мэдээллийг авахаар УЕП-ын газарт хандсан боловч “цахим бүртгэлийн системд шинэчлэлт хийгдээгүй тул нарийвчилсан тоон судалгааг гаргах боломжгүй” гэсэн хариу өгсөн болно.

Судалгаанд хамрагдсан 14 прокурорын 57% нь яллагдагчид хязгаарлалт тогтоох ТСАХ авахуулах саналаа шүүхэд гарган шийдвэрлүүлсэн байна. Энэ нь прокурор өөрийн санаачилгаар яллагдагчид хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авахуулсан шүүхийн практик тогтоход эерэгээр нөлөөлжээ.

Яллагдагчид хязгаарлалт тогтоох ТСАХ авахуулах санал гаргаагүй прокуроруудын хувьд ихэнх нь одоогийн мөрдөж буй хуулийн зохицуулалтын хүрээнд хяналтын төхөөрөмж ашиглан хяналт тавих нөхцөл боломж бүрдээгүй тул санал гаргаагүй гэж тайлбарласан. Энэ нь “Мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан заавар”²³-ын 6.6 дугаар зүйлийн 6-д “хяналтын төхөөрөмжөөр хангагдаагүй нөхцөлд прокурор хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх санал гаргахаас татгалзана.” гэсэн зохицуулалттай холбоотой байна.

Хязгаарлалт тогтоох ТСАХ-г орон нутагт хэрэглэх боломж огт байхгүй. Техникийн хяналт байхгүй тул уулын мухарт байгаа хүнийг хэн, хэрхэн, яаж хянах вэ. Тийм болохоор саналаа гаргаад очсон ч хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхгүйгээр шүүх цагдан хорих ТСАХ авчихдаг.

Прокурортой хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс


20 УЕП-ын 2017 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/96 дугаар тушаалын хавсралт (Мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан заавар)

21 ЭХХШ тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

22 ЭХХШ тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

23 УЕП-ын 2017 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/96 дугаар тушаалын хавсралт

Зураг 3. Прокуророос хязгаарлалт тогтоох ТСАХ авахуулах санал гаргахгүй байгаа шалтгаан



Зарим прокурор хэргийн оролцогчоос санал гаргаагүй бол өөрийн санаачилгаар ТСАХ авах боломжгүй гэсэн ойлголттой байгаа нь ЭХХШ тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан прокурорын чиг үүрэгтэй зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл, ЭХХША-ны аль ч үед яллагдагчид хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авах санал, хүсэлтээ шүүхэд гаргах талаарх прокурорын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хэргийн оролцогчоос яллагдагчид хязгаарлалт тогтоох ТСАХ авахуулах тухай хүсэлт гаргаагүй байх явдал саад болох ёсгүй.

Нөгөө талаар мөрдөгч, прокуроруудын дунд хязгаарлалт тогтоох ТСАХ-г ЭХХШ тухай хуулийн Арван гуравдугаар бүлэгт заасан Гэрч хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээтэй хольж ойлгож байгаа нь ажиглагдлаа.

ЭХХШ тухай хуулийн 13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд гэрч, хохирогч, өмгөөлөгч хүсэлт, мөрдөгч санал гаргасан бол Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шийдвэрийг прокурор, шүүгч гаргахаар заасан.

Энэ зохицуулалтын дагуу прокурор хязгаарлалт тогтоох ТСАХ авах саналаа шүүхэд гаргахын тулд заавал хохирогч болон өмгөөлөгчөөс гаргасан хүсэлтийг үндэслэх ёстой гэсэн ташаа ойлголттой байна.

2.7. Хохирогч, түүний өмгөөлөгчөөс яллагдагчид хязгаарлалт тогтоох ТСАХ авахуулах болон ТСАХ-г өөрчлүүлэх хүсэлт гаргаж шийдвэрлүүлж буй байдал

Хэргийн оролцогч, өмгөөлөгч нартай хийсэн ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын явцад 4 өмгөөлөгчийн зүгээс сэжигтэн, яллагдагчид хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авахуулах тухай хүсэлтээ мөрдөгч, прокурорт гаргасан байна.

Өмгөөлөгч, хохирогчийн хүсэлтийг прокурор хүлээн авч, яллагдагчид хязгаарлалт тогтоох ТСАХ авахуулах тухай саналаа тавьсан ч шүүхээс прокурорын тавьсан ТСАХ-г өөрчилж яллагдагчийг цагдан хорихоор шийдвэрлэсэн байна.

-Үйлчлүүлэгч маань "Нөхөр намайг зодоод хэрэг нь цагдаа дээр шалгагдаж байгаа юм. Намайг өргөдлөө буцааж ав гээд утсаар байнга дарамталж байна. Саяхан намайг мөрдөж байгаад ажлын гаднаас барьж аваад машиндаа хүчээр суулгаж гэртээ аваачсан. Тэгээд зодож, хүчээр бэлгийн харьцаанд оруулсан. Би байцаагчдаа хэлсэн. Шинжээчийн дүгнэлт гараагүй байгаа болохоор яах ч арга байхгүй гэх юм. Нөхөр цагдаа дээр очихгүй зугатаад байгаа мөртлөө шөнө оройн цагаар аав ээж рүү утасдаад амьд үлдээхгүй гээд байна." гэхээр нь прокурорт хүсэлтээ гаргаж өгсөн. Прокурор холбогдогчид хязгаарлалт тогтоох ТСАХ авахуулах саналаа шүүхэд гаргасан чинь шүүгч "оргон зайлж болзошгүй" гэсэн үндэслэлээр саналыг өөрчилж, цагдан хорих ТСАХ авсан байна.

Өмгөөлөгчтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл


Хязгаарлалт тогтоох ТСАХ-г өөрчлүүлэх тухай хүсэлт гарган шийдвэрлүүлсэн тохиолдол байхгүй байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаар гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх үүргийг хуулиар хүлээсэн албан тушаалтан нь хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний аюулгүй байдлыг хангах, даруй тусгаарлах арга хэмжээг авах, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, явц, нөхцөл байдал, хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэсэн хариуцлагын талаархи мэдээллийг хохирогчид танилцуулж, тайлбарлан өгөх үүрэгтэй²⁴.

Хохирогчидтой хийсэн фокус бүлгийн ярилцлагаар эрүүгийн хэрэг үүсгээд шалгаж байх хугацаанд таны болон гэр бүлийн бусад гишүүдийн амь нас,

24 ГБХТ тухай хуулийн 8 дугаар зүйл

эрүүл мэндэд аюул учрах болзошгүй байдал үүссэн эсэхийг тодруулахад 55% нь тийм гэж хариулсан бөгөөд энэ тохиолдолд Та ямар арга хэмжээ авах вэ? гэсэн асуултад 45.9% нь мөрдөгчдөө хэлнэ гэсэн бол, 30.6% нь “сайн мэдэхгүй байна” гэж хариулсан нь ГБХТ тухай хуулийн дээрх зохицуулалт хангалттай хэрэгжихгүй байгааг харуулж байна.



ЭХХШ ажиллагааны явцад хохирогчийн эрхийг танилцуулах байдал хангалтгүйгээс тэдний хуулийн хүрээнд аюулгүй байдлаа хэрхэн хамгаалуулах талаарх ойлголт мэдлэг сул байна

2.8. Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж буй байдал

ЭХХШ тухай хуульд хязгаарлалт тогтоох ТСАХ-ний хэрэгжилтэд хэн хяналт тавихыг тодорхой заагаагүй байна.

ЭХХШ тухай хуулийн 14.5 дугаар зүйлийн 2-т “Хязгаарлалт тогтоох ТСАХ авсан, хүчингүй болгосон тухай шүүхийн шийдвэрийг прокурор, мөрдөгч хяналт тавих байгууллагад даруй мэдэгдэнэ”, мөн зүйлийн 3-т: “Шүүхийн шийдвэрт яллагдагчийн очих, оршин суух, ажиллах, зорчих газар, тодорхой хүнтэй уулзахгүй, харилцахгүй байхыг зааж, хяналт тавихыг эрх бүхий байгууллагад даалгана”, мөн зүйлийн 4-т: “Шүүхийн шийдвэрт заасан бол хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллага нь яллагдагчид хяналтын төхөөрөмж ашиглан хяналт тавина” гэж тус тус зааснаас үзвэл хязгаарлалт тогтоох ТСАХ-ний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий, прокурор, мөрдөгчөөс тусдаа байгууллага, албан тушаалтан байхаар ойлгогдож байна.


Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журмын Тавдугаар бүлгийн 5.5-д “Алба хаагч нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн сэжигтэн, яллагдагч,

шүүгдэгч нь цагдан хорихоос бусад таслан сэргийлэх арга хэмжээ, албадлагын бусад арга хэмжээ авагдсан тохиолдолд өөрөө биечлэн тухайн баг, хороо хариуцсан цагдаагийн алба хаагчид мэдэгдэж, хяналт тавиулна”²⁵ гэж заасан байна. Эндээс яллагдагчийн амьдарч байгаа баг, хороо хариуцсан цагдаагийн алба хаагч хязгаарлалт тогтоох ТСАХ-ний хэрэгжилтэд хяналт тавьж болох үндэслэл харагдаж байна. Үүнээс өөрөөр хязгаарлалт тогтоох ТСАХ-ний хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой тусгайлсан журам байхгүй байна.

Ийнхүү ЭХХШ тухай хуулийн хязгаарлалт тогтоох ТСАХ-тэй холбоотой зохицуулалтын бүрхэг, ойлгомжгүй байдал нь уг арга хэмжээг практикт хэрэглэхэд хүндрэл учруулж байгааг анхаарах шаардлагатай.

Шүүгч захирамждаа хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хэн, хэрхэн хяналт тавихыг тодорхой заадаггүй нь дээрх хуулийн тодорхойгүй байдалтай холбоотой.

Мониторингийн явцад хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хяналтыг хэн, хэрхэн хариуцан ажиллаж байна? гэсэн асуултад прокурорууд доорхи байдлаар хариулсан.



Хөдөө орон нутагт тодорхой газар очихыг хориглох, тодорхой хүнтэй уулзахыг хориглох арга хэмжээг яг одоогоор биелүүлэх боломжгүй байгаа. Хохирогч энэ таслан сэргийлэх арга хэмжээг зөрчөөд байна гэж хэлбэл өөр арга хэмжээгээр солих боломжтой гэж шүүгч тайлбарласан байна²⁶.

25 УЕП, ХЗДХ-ийн сайдын 2017 оны 2-р сарын 9-ний А/22, А/31 тоот тушаалаар батлагдсан 26 Шүүгчтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл, 2020 он

Хязгаарлалт тогтоох ТСАХ-ний төрлүүдээс Монгол Улсын Хилээр гарахыг хязгаарлах арга хэмжээ нь хэрэгжихэд арай тодорхой байдаг. Хил хамгаалах газар болон гадаадын иргэн, харьяатын албанд хүсэлт өгөөд биелүүлэх боломжтой гэж шүүгч тайлбарласан²⁷.

Монгол Улсын өмнөх ЭХХШ тухай хуулиудад техникийн хяналт ашиглан хяналт тавих хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ байгаагүй, шинэ төрлийн ТСАХ учир энэ төрлийн ТСАХ-г хэрэгжүүлэх тусгай журам шаардлагатай гэж үзлээ.

2.9. Хязгаарлалт тогтоох ТСАХ-г хэрэгжүүлэх боломж

Монгол Улсад ЭХХШ тухай хуулийг дагаж мөрдөөд 3 жил өнгөрч байна. Уг хуулиар яллагдагч, шүүгчдэгчид авах таслан сэргийлэх арга хэмжээний төрөл хэлбэрийг өргөжүүлэн, цагдан хорихоос өөр төрлийн албадлагын шинжтэй хязгаарлах арга хэмжээг нэмэгдүүлсний нэг нь “хязгаарлалт тогтоох” ТСАХ юм.

Өнгөрсөн хугацаанд “Тогтоосон замаар зорчихыг даалгах”-аас бусад төрлийн хязгаарлалт тогтоох ТСАХ-г шүүхүүд практикт хэрэглэжээ. Гэвч уг ТСАХ-г авсан шүүгчийн захирамжийн хэрэгжилтэд техникийн хяналт тавьсан тохиолдол байхгүй байна.

Өнөөгийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн тодорхой хэдэн зүйл заалтуудаар техникийн хяналтыг зохицуулсан нь Эрүүгийн хуульд заасан зорчих эрхийг хязгаарлах ял²⁸, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах ял албадлагын арга хэмжээ хэрэглэх шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэхтэй холбоотой байна. (ШШГТХ-ийн 167, 168, 169, 170, 171)²⁹.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих үүрэг хүлээлгэх, тодорхой хүнтэй, бусадтай харилцахыг хориглох ... г.м төрлүүдтэй.

Мөн Эрүүгийн хуульд³⁰ гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нь нэмж хэрэглэх албадлагын арга

27 Шүүгчтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл, 2020 он

28 Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.5 дугаар зүйл

29 Хууль сахиулахуй сэтгүүл, 2016 оны 02 (18) дугаар, 80 дахь тал

30 Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.2 дугаар зүйл

хэмжээний төрлийг шинээр нэмсэн. Энэ нь үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ байна. Уг арга хэмжээний төрөл дотор “тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах” албадлагын арга хэмжээ тусгагдсан байна.

Эрүүгийн хуулийн дээрх ял, албадлагын арга хэмжээнүүд ЭХХШ тухай хуулийн 14.5 дугаар зүйлд заасан хязгаарлалт тогтоох ТСАХ-ний төрлүүдтэй давхцаж байна. Тухайлбал, “тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох, тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгах” г.м.

Хууль тогтоогчоос зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх хугацааг хэрэглэх цахим төхөөрөмжтэй холбоотойгоор удаа дараа хойшлуулсны эцэст Засгийн газрын хурлаас 2021 оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжүүлэх нь зөв гэж үзээд тогтоол гаргаж, холбогдох ажлуудаа хийж эхэлж байна³¹.

Эрүүгийн хуульд орсон ялыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цахим хяналтын төв Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт байрлана гэж тооцсон. Цаашдаа уг төвийн барилга байгууламжийг барих, нэгдсэн хяналтын төвтэй болохоор зорьж байна.

Улаанбаатар хот дахь хяналтын төвдөө болон орон нутаг дахь манай байгууллагын харьяа нэгжүүдэд уг ялыг хэрэгжүүлэх ажил хариуцсан алба хаагчид ажиллах юм.

Хэрэв зорчих эрх хязгаарлах ялыг хэрэгжүүлэх ажил үр дүнтэй байвал, хоёрдугаарт энэ төхөөрөмжийг таслан сэргийлэх арга хэмжээнд хэрэглэж болно. Хуульд тодорхой хэмжээний өөрчлөлт оруулж байж хэрэглэх болов уу.

*ИШГЕГ-ын тэргүүн дэд дарга, хурандаа Д.Дамдинцэрэн, ярилцлага,
2020 он, <https://mojha.gov.mn/newtojha/?p=4172>*

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зарим төрлийн ТСАХ, тухайлбал, сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих тухай шүүгчийн захирамжийг биелүүлэх ажиллагааг хэрэгжүүлж байна³².

31 Д.Дамдинцэрэн: “Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлснээр хүний эрхийг дээдлэхийн зэрэгцээ эдийн засагт ч хэмнэлттэй” ярилцлага, 2020 он, <https://mojha.gov.mn/newtojha/?p=4172>

32 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг

Иймд ЭХХШ тухай хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд нэмэлт оруулах замаар хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийг нэгдсэн хяналтын тогтолцоонд оруулах боломжтой гэж дүгнэв.

ДҮГНЭЛТ

ЭХХШ тухай хууль хэрэгжээд 3 жил болж буй хэдий ч гэр бүлийн хүчирхийллийн холбогдолтой гэмт хэрэгт уг хуулийн 14.5 дугаар зүйлд заасан хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг төдийлөн хэрэглэхгүй байгаа нь доорхи шалтгаантай байна:

1. Хязгаарлалт тогтоох ТСАХ хэн, хэрхэн хэрэгжүүлэх талаарх нарийвчилсан эрх зүйн зохицуулалт байхгүй байна.
2. Хязгаарлалт тогтоох ТСАХ-г ямар байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хэн, хэрхэн хяналт тавих нь тодорхойгүй байгаагаас уг арга хэмжээг шүүх хэрэглэхэд хүндрэлтэй байна. ЭХХШ тухай хуульд “хяналт тавих байгууллага”, “эрх бүхий байгууллага” гэж заасан нь ойлгомжгүй байна.
3. Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх зарим арга хэмжээний хэрэгжилтэд хяналтын төхөөрөмж ашиглан хяналт тавихаар хуульчилсан боловч уг төхөөрөмж болон техник хэрэгсэл, бэлтгэгдсэн хүний нөөц байхгүйгээс хэрэгжилт нь хангалтгүй байна.
4. Уг таслан сэргийлэх арга хэмжээний зорилго, ач холбогдол болон практикт хэрхэн хэрэглэх талаар хуульчдын мэдлэг, ойлголт сул байна. Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээнээс ялгаж ойлгохгүй байна.

ЗӨВЛӨМЖ

1. Мониторингийн үр дүнд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна:
2. ЭХХШ тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хязгаарлалт тогтоох ТСАХ-ний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хариуцуулах;
3. Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга эмжээг практикт хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, хяналтын техник тоног төхөөрөмжөөр хангах, уг ТСАХ-г хэрэгжүүлэхтэй холбоотой төсөв, хөрөнгийг шийдвэрлэх;
4. ЭХХШ тухай хуулийн 14.5 дахь хэсэгт заасан хязгаарлалт тогтоох арга хэмжээ нь шинэ төрлийн ТСАХ учир шүүгч, мөрдөгч, прокуроруудад мэдээлэл өгөх, сургалт явуулах.